

**Храдэц Краловэ дахь Нигүүлсэнгүй (харита) католик шашинтны тамгын газрын
зөвлөх товчооноос гадаадын иргэд, дүрвэгсдэд үйлчлэх, зөвлөгөө өгөх тухай
мэдээлэл**

Зөвлөгөө өгөх төвийн зорилго юу вэ?

Гадаад иргэд болон дүрвэгсдэд зориулан арьсны өнгө, үндэс угсаа, нийгмийн бүлэг, улс төрийн итгэл үнэмшил, шашин шүтлэгээс үл хамааран нийгэмд нэгдэхэд нь дэмжлэг үзүүлж төрөл бүрийн мэргэжлийн зөвлөгөөг **үнэ төлбөргүй** үзүүлэх болно.

Бидний зорилго?

- 1) *Гадаадын иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх улмаар нийгмийн болон хууль зүйн зөвлөгөө өгөх (ялангуяа: Чех улсад оршин суух, хөдөлмөр эрхлэх, ажил эрхлэлт, орон сууц, нийгмийн систем, боловсрол, эрүүл мэнд, даатгал, бизнес эрхлэх гэх мэт) мөн тэдний нийгэм-соёлын чиг хандлага хандлагыг бэхжүүлэх.*
- 2) *Дагаж мөрдөх үйлчилгээнд байгаа холбоо барих хаягаар хангах (материаллаг тусламж үзүүлэх, интеграцчилах, дасан зохицох явцад туслах, боловсролын үйл ажиллагаа, курсүүд, байр орон сууцны тавилга болон бусад хэрэгслүүд), БН Чех Улсын бусад Харитагийн салбаруудтай харилцах мэдээлэл (Гадаад иргэдийн цагдаагийн газар, ЦШХБГ, бүс нутгийн эрх барих байгууллага, хотын захиргаа, төрийн бус байгууллагууд гэх мэт) эдгээр байгууллагатай харилцах харилцааг сайжруулах.*
- 3) *Гадаадын иргэн өөр соёлын орчинд амьдрах, гэр бүл, хамтрагчийн харилцаа, бусад стресс, амьдралын хямрал зэрэгтэй холбоотой өнөөгийн сэтгэлзүйн хүндрэлийг даван туулах эсвэл багасгахад сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх.*

Зөвлөгөө өгөх төв хэнд тусалдаг вэ?

Гадаадын иргэд болон дүрвэгсдэд ялангуяа нийгмийн нөхцөл байдлаасаа болоод эсвэл оршин суух статус, хэлний бэрхшээл, соёлын ялгаа, тэдний эрх үүргээ мэдэхгүй эсвэл амьдралын эмзэг байдалд орсон хүмүүст.
Үйлчилгээг **бүх насны хүмүүст** үзүүлэх боломжтой. **Насанд хүрээгүй** гадаадын иргэдэд дараах нөхцлөөр:

Нийгмийн болон хууль зүйн зөвлөгөө

0-15 насны гадаадын хүүхдүүд

15 хүртэлх насны хүүхдийн амьдралын тулгамдсан асуудлыг зөвхөн хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчидтай харьцаж шийдвэрлэдэг.

15 – 18 насны гадаадын хүүхдүүд

15-18 насны үйлчлүүлэгчид нь тус зөвлөгөө үйлчилгээг бие даан ашиглах боломжтой. Гэсэн хэдий ч зөвлөх төвийн ажилтан гадаадын иргэний нас, БН Чех Улсад хууль

ёсны төлөөлөгч эсвэл асран хамгаалагчтай эсэхийг шалгадаг мөн цаашлаад тулгамдсан таагүй асуудлыг ие даан шийдэж чадах нь илт харагдаж байгаа эсэхийг авч үзнэ. Гэхдээ зөвлөгөө өгөх төвийн ажилтан нь насанд хүрээгүй хүүхдийн ашиг сонирхлын үүднээс хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчтай хамтран ажиллаж болно.

Насанд хүрээгүй хүүхдэд хамт дагалдаж яваа хүнгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэх боломжгүй ба хүүхдийн нийгэм, эрх зүйн хамгааллын хэлтэс хүүхэдтэй хамтран ажиллахыг зөвшөөрсөн үед үйлчилгээ тусламж үзүүлж болно.

Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх

0-15 насны насанд хүрээгүй гадаадын иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгнө.

15-аас доош насны хүүхдэд үзүүлэх сэтгэлзүйн зөвлөгөөг зөвхөн хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн зөвшөөрлөөр авах боломжтой. Үйлчлүүлэгчийн картыг хүүхдэд зориулж бөглөж, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч гарын үсэг зурна.

15-18 насны гадаадын иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгнө.

15-18 насны үйлчлүүлэгч тус үйлчилгээг бие даан авах боломжтой. Харин зөвлөх төвийн ажилтан гадаадын иргэний нас, БНЧУ-д хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчтай эсэх, нийгмийн таагүй нөхцөл байдлаа бие даан шийдвэрлэх боломжтой эсэхийг шалгадаг ба зөвлөгөө өгөх төв нь насанд хүрээгүй хүүхдийн ашиг сонирхлын үүднээс хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчтай хамтран ажиллаж болно. Сэтгэлзүйн зөвлөгөөний нэг хэсэг болох эмчилгээг насанд хүрээгүй хүүхдийг 18 нас хүртэл эцэг эхийн зөвшөөрлөөр хийдэг.

Бид ямар тохиолдолд зөвлөгөө өгөх вэ?

- Хэрэв та БН Чех Улсад оршин суух эрхээ алдахад хүргэж болзошгүй эрх, үүргээ мэдэхгүй бол;
- Таны бие даах чадвар, шийдвэр гаргах эрх чөлөөг тань хязгаарладаг зуучлагчаас хамааралтай,
- та чех хэлийг хангалттай сайн мэдэхгүй байгаа нь ажилд ороход хүндрэлтэй, зуучлагчаас хамааралтай, нийгмийн тогтолцооны тэтгэмж гэх мэт.
- Та арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, оршин суугаа байдал эсвэл нийгэм соёлын хэм хэмжээг үл тоомсорлосны улмаас нийгмээс гадуурхагдах эрсдэлтэй байдал.
- та ганцаардмал мэт санагдах бөгөөд энэ нь бухимдал, сэтгэл зүйн асуудал, нийгэмд нэгдэх чадваргүй болоход хүргэдэг
- Хэрэв та өөр соёлын орчинд, гэр бүл, хамтрагчийн харилцаа эсвэл бусад стресс, амьдралын хямралтай холбоотой сэтгэлзүйн бэрхшээлтэй байгаа бөгөөд хэлний бэрхшээл эсвэл нийгмийн бусад таагүй нөхцөл байдлын улмаас сэтгэлзүйн өөр тусламж авч чадахгүй байна.

Зөвлөгөө өгөх төвийн ажиллах зарчим?

ҮНЭГҮЙ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛЖ, НЭГ ТАЛЫГ БАРИМТЛАХГҮЙ БАЙХ

Мөн зөвлөгөө өгөх төвийн ажилтнууд хүний эрх, үндсэн эрх чөлөө, хувийн мэдээллийг хамгаалах дүрэм, мэдээллийн нууцлалыг хадгалж, үйлчлүүлэгч тус бүртэй хувь ганцаарчилж харьцах харилцааг хангаж ажилладаг.

Ямар хэлээр харилцаж болох вэ?

Манай зөвлөгөө өгөх газарт чех, орос, англи, украин, монгол хэлээр харьцаж болох бөгөөд өөр хэлээр ярих тохиолдолд өөрөө орчуулагчтай ирэх шаардлагатай. Хэрэв танд жагсаасан хэлээр орчуулга хийх шаардлагатай бол урьдчилан захиалж үйлчилгээ авах шаардлагатай. Хэрэв та цаг авалгүй ирвэл орчуулагч байхгүй байх боломжтой.

Манай зөвлөгөө өгөх төвд Танд хэн үйлчлэх вэ?

Тухайн салбарт олон жил ажилласан туршлагатай нийгмийн ажилтнууд байдаг бөгөөд мөн бид гадаад иргэд, дүрвэгсдийн асуудлаар мэргэшсэн хуулийн ажилтан, сэтгэл зүйч, орчуулагч нар ажилладаг (интеграцчилалын ажилтнууд).

Хаана, хэдийд манай үйлчилгээг авч болох вэ?

Дараах хаягаар манай байгууллага дээр биечлэн ирж үйлчлүүлж болно

Гадаадын иргэд болон дүрвэгсдэд зөвлөгөө өгөх газар

Diecézní katolická charita Hradec Králové

Šafaříkova 666/9

500 02 Hradec Králové

Холбоо барих:

tel.: 492604940, 731402301, 731402303

e-mail.: poradna.cizinci@hk.caritas.cz

www.hk.caritas.cz, www.cizincihradec.cz

Храдэц Краловэ мужийн нутаг дэвсгэрт мөн явж үйлчилгээ үзүүлнэ. Бидэнтэй утсаар болон и-мэйл бичиж цахим хэлбэрээр холбоо тогтоож болно.

Цагийн хуваарь:

	Байгууллагын байранд зөвлөгөө өгөх	Гадуур ажиллах цаг
Даваа	8:00- 12:00 13:00-17:00	9:00-12:00 13:00-16:00
Мягмар	9:00-12:00 13:00-16:00	
Лхагва	8:00-12:00 13:00-17:00	9:00-12:00 13:00-16:00

Холбоо барьж урьдчилан товлосон цагт зөвлөгөө өгөх боломжтой.

Манай зөвлөх үйлчилгээ яаж явагддаг вэ?

Анхны холбоо барих үедээ зөвлөгөө өгөх төвийн ажилтантай ямар хэлээр харилцах талаар тохиролцох болно. Мөн зөвлөх төвийн ажилтан танд санал болгож буй үйлчилгээний хамрах хүрээ, төрөл, нөхцөл, хүртээмжийн талаар мэдээлэх болно. Зөвлөх таныг нийгмийн эмзэг байдалд байгаа эсэх (Бид ямар нөхцөл байдалд тусалдаг хэсгийг үзнэ үү) болон таны даалгавар юу болохыг тодорхойлдог. Захиалга гэдэг нь зөвлөгөө өгөх төвд ирж, шийдвэрлэхийг хүссэн үйлчлүүлэгчийн хэрэгцээ юм. Дараа нь та ямар үйлчилгээ, ямар хэмжээгээр ашиглахаа шийдэж, сонгоно. Таны шийдвэр, сонголтыг зөвлөх хүлээн авах болно. Нөхцөл байдлыг сайжруулахын тулд хүрэхийг хүсч буй зорилгоо хамтдаа тохиролцох

болно. Зорилго нь таны даалгавар болон үйлчилгээний санал болгож буй сонголтууд дээр суурилдаг. Бид тавьсан зорилгодоо тулгуурлан манай ажилтнуудын хийх, та бүхний хийх дэд ажлуудыг төлөвлөнө. Зөвлөгөө өгөх төвийн ажилтантай хамт тавьсан

Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, тусламж үзүүлэх ажлын онцлог

Сэтгэл зүйч нь бүх зөвлөх ажилтнуудын нэгэн адил нууцлалыг чанд баримталдаг. Гэсэн хэдий ч, таны хувийн зорилгод хүрэх, нийгмийн эмзэг байдлыг сайжруулахын тулд таны нийгмийн ерөнхий байдалд нөлөөлж болох чухал мэдээллийг бүх зөвлөх багийнхантай хуваалцаж болно. Хэрэв та сэтгэлзүйн зөвлөгөөний нэг хэсэг болгон эмчилгээг ашиглахыг сэтгэл зүйчтэй зөвшөөрвөл тус бүр нь 50 минутын хугацаатай 10 хуралдаан хийж, эмчилгээний зорилгыг үнэлж, цаашдын үйл ажиллагааны талаар авч үзэх боломжтой. Хэрэв та сэтгэл зүйчтэй уулзахаас дор хаяж 24 цагийн өмнө өөрийгөө зөвтгөөгүй бол сэтгэлзүйн зөвлөгөөг 2 сараар зогсоож болно.

Та манай байгууллагатай алсын зайнаас харилцах боломжтой байдлаар ажилтантай холбогдох боломжтой. Энэ тохиолдолд үйлчилгээг хувийн зөвлөгөө авахтай адил нөхцөлөөр хийхээр төлөвлөж байгаа боловч хэрэв та үйлчилгээг бүрэн хэмжээгээр ашиглахыг хүсвэл зөвлөгөө өгөх төвд өөрийн биеэр очиж, үйлчлүүлэгчийн картыг бөглөх шаардлагатай. Дараа дараагийн уулзалтууд алсаас харилцах замаар явагдах боломжтой.

Хувийн мэдээллийг хамгаалах тухай үйлчлүүлэгчдэд зориулсан мэдээлэл

Diecézní katolická charita Hradec Králové байгууллага гадаад иргэд болон дүрвэгсэдийн зөвлөгөө өгөх төв нь чанартай үйлчилгээ үзүүлэхийн тулд ихэвчлэн Зөвлөгөө өгөх төвийн тодорхой ажилд туслах шаардлагатай таны зарим хувийн мэдээллийг авах хэрэгтэй байдаг. Нийгмийн үйлчилгээтэй холбоотой хэрэгжиж буй төслүүдийн хэрэгцээнд зарим мэдээлэл шаардлагатай байдаг. Эдгээр шалтгааны улмаас нийгмийн ажилтан болон манай зөвлөгөө өгдөг бусад ажилтнууд танаас үйлчлүүлэгчийн карт дахь мэдээллийг бөглөхийг хүсэх болно. Хувийн мэдээллийг боловсруулах тухай мэдээлэл нь тусдаа баримт бичигт олон хэл дээр тухайн байгууллагын вэбсайтад эсвэл гадаадын иргэд, дүрвэгсдэд зориулсан зөвлөгөө өгөх төвийн мэдээллийн самбар дээр байдаг. Үйлчилгээ үзүүлэх үед та нэрээ нууцалж болно. Хэрэв та зарим шаардлагатай мэдээллийг өгөхгүй бол үйлчилгээг бүрэн авах боломжгүй байж магадгүй юм. Энэ баримтаар ажилтан таньд тодорхой анхааруулах болно.

Хувийн бүхий л мэдээлэлтэй манай ажилтнууд болгоомжтой харьцаж, мэдэх ёсгүй хүмүүст үзүүлэхгүй байх, хууль бусаар ашиглахаас сэргийлж байх бөгөөд нууцыг хадгалах үүрэгтэй билээ.

Үйлчлүүлэгч бүр түлхүүр ажилтан гэж нэрлэгдэх өөрийн хариуцсан ажилтантай байх бөгөөд энэ нь үйлчилгээ үзүүлэх талаарх төлөвлөгөө боловсруулах, дүгнэлт хийх, Тантай хамтран ажиллаж асуудлыг шийдэгдтэл тусалж үйлчлэх юм. Уг ажилтан байхгүй байгаа тохиолдолд өөр ажилтан түүнийг орлож Танд үйлчилнэ. Хэрвээ түлхүүр ажилтан солигдохыг Та зөвшөөрөхгүй бол Таны хүссэн түлхүүр ажилтантай хэзээ уулзах хугацааг тохиролцоно. Хийгдсэн ажил үйлчилгээ болгоны талаар зөвлөгөө өгөх газрын ажилтан тэмдэглэл протокол хөтлөн хэрэглэгчдийн мэдээллийн санд хадгална. Уг мэдээллийн санд зөвхөн тухайн зөвлөгөө өгөх газрын ажилтнууд болон шаардлагатай үед захирал эсвэл хянах байгууллагын ажилтан л орж үзэх эрхтэй. Та ч мөн манай ажилтантай тохирлцсоны үндсэн дээр хүссэн үедээ өөрийн мэдээллийн сан руу орж үзэх эрхтэй. Хэрвээ Та мэдээллийн санд өөрийн тухай мэдээллийг оруулахыг хүсэхгүй бол статистик бүртгэлийн зорилгоор зөвхөн нэр нууцалсан мэдээ үлдэх болно.

Нэрээ нууцлах

Та нэрээ нууцалж манай үйлчилгээг ашиглаж болно. Гэсэн хэдий ч, 15-аас доош насны гадаадын иргэдэд үйлчилгээг тусад нь үзүүлэх боломжгүй тул ажилтан таны насыг зайлшгүй баталгаажуулах ёстой. Хэрэв та шаардлагатай зарим мэдээллийг өгөхгүй бол үйлчилгээг бүрэн хэмжээгээр нь өгөх боломжгүй байж болно. Энэ талаар ажилтан танд тодорхой мэдээлэх болно. Гэсэн хэдий ч нэрээ нууцалсан тохиолдолд ч гэсэн мэдээллийн санд үйлчилгээ үзүүлж байгааг бүртгэх шаардлагатай.

Та болон ажилчин таныг хэрхэн дуудах талаар тохиролцох хэрэгтэй ба жишээлбэл. овог нэр, хоч, бусад нэршил, таны иргэний харьяалал, оршин суух зөөвшөөрлийн ангилал, ойролцоо насыг мөн бүртгэнэ.

Үйлчилгээний нэргүй хэрэглэгчид сэтгэл зүйчийн зөвлөгөө авах боломжгүй ба учир нь сэтгэл зүйч болон үйлчилгээний хэрэглэгчийн хооронд итгэлцлийг бий болгох шаардлагатай.

Хариуцсан ажилтан

Хэрэглэгч бүр өөрийн гэсэн байнгын гол ажилтантай харилцах бөгөөд та түүнтэй хамт үйлчилгээний төлөвлөгөө хийж мөн үнэлгээ өгнө. Хариуцсан ажилтан бол тантай хамтран ажиллаж, урт хугацаанд үйлчилгээ үзүүлэх хүн юм. Хэрэв хариуцсан ажилтан байхгүй бол одоо ажиллаж байгаа ажилтан таны зөвшөөрлөөр түүний үүргийг хүлээн авна. Хэрэв та энэ өөрчлөлтийг зөвшөөрөхгүй бол таныг хариуцсан ажилтантай уулзах өдрийг тохиролцож болно.

Үйлчилгээний бүртгэл

Зөвлөгөө өгөх төвийн ажилтан уулзаж зөвлөгөө өгсөн үйлчилгээ бүрийн бүртгэлийг үйлчлүүлэгчийн мэдээллийн санд хадгалдаг. Зөвхөн зөвлөгөө өгөх төвийн ажилтнууд эсвэл зохицуулах байгууллага гэх мэт эрх бүхий ажилтнууд энэ мэдээлэлд хандах боломжтой. Мөн та зөвлөгөө өгөх төвийн ажилтантай зөвлөлдсөний дараа хүссэн үедээ бүртгэлээ үзэх эрхтэй. Уулзалтын үед дуу болон дүрс бичлэг хийх хориотой. Гэсэн хэдий ч та тэмдэглэл бичиж, вэбсайт дээрх чухал мэдээллийн зургийг авах эсвэл манай ажилтантай тохиролцож амьдралынхаа нөхцөл байдлыг шийдвэрлэхэд хэрэгтэй чухал мэдээллийн тоймыг и-мэйлээр авч болно.

Та манай зөвлөх төвийн үйлчилгээг өөрөө цуцалж болох үү?

Та хүссэн үедээ үйлчилгээгээ цуцлах эрхтэй. Энэхүү шийдвэрийг зөвлөгөө өгөх төвийн ажилтнууд бүрэн хүндэтгэж байна

Онцгой тохиолдолд зөвлөгөө өгөх төв дараахь үйлчилгээг үзүүлэхээс татгалзаж болно:

- Бид таны хүссэн үйлчилгээг үзүүлэхгүй байх
- Та манай үйлчилгээний зорилтот бүлэгт хамаарахгүй тохиолдолд
- Зөвлөгөө өгөх төв шинээр харилцагч хүлээн авах боломжгүй үед

Та манай үйлчилгээнд сэтгэл хангалуун бүс байна үү эсвэл ямар нэг зүйлийг үнэлж сайшаах үү?

Та санал хүсэлт, үйлчилгээг сайжруулах санал эсвэл сайшаалыг дараах хэлбэрээр илгээж болно:

1. Цаасан дээр бичээд хонгилын "хүсэл, гомдол" гэсэн хайрцагт хийж болно
2. Асуултын хүснэгт бөглөх – зөвлөгөө өгөх төвд байгаа
3. Цахим санал хүсэлтийн маягтыг бөглөнө үү – санал хүсэлтийн хайрцган дээрээс QR код харж болно

Хэрэв санал, хүсэлтэд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлж, гомдол гаргагч холбоо барих хаягаа өгсөн бол гомдол гаргах боломж, түүний журмын талаар мэдэгдэнэ.

Санал гомдол

Гомдол гэдэг нь нийгмийн үйлчилгээний чанар, арга хэлбэрт сэтгэл ханамжгүй байгаа тухай мэдээлэл юм. Гомдлыг зохих ёсоор шийдвэрлэхийн тулд гомдол гаргагч нь гомдлыг зохих ёсоор бичгээр шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллийг (доороос үзнэ үү) өгөх ёстой.

Хэрэв тэдгээрийг тодорхой хэлээгүй бол түүний мэдэгдлийг гомдлын горимд оруулаагүй, харин тайлбар, санал хувьд авч үзэх болно.

Санал гомдлыг хэрхэн гаргах вэ?

1. Бичгээр гомдол гаргах

Бичгээр гаргасан гомдлыг хүлээж авсны дараа гомдлын дэвтэрт бүртгэж, гомдлыг шийдвэрлэсэн хариуг гомдолд заасан хаягаар шуудангаар илгээнэ

2. Амаар гомдол гаргах

Зөвлөгөө өгөх төвийн ажилтан таны гомдлыг гомдлын дэвтэрт бүртгэж, гомдлыг шийдвэрлэх арга, шийдвэрлэсэн мэдээллийг хүлээлгэн өгөх газрын талаар тохиролцоно

3. Цахим хэлбэрээр гомдол гаргах

Цахимаар гаргасан гомдлыг хүлээж авсны дараа гомдлын дэвтэрт бүртгэж, гомдлыг шийдвэрлэсэн хариуг гомдолд заасан хаягаар цахимаар илгээнэ.

Хэн санал гомдол гаргах боломжтой вэ?

а) нийгмийн үйлчилгээнд хамрагдаж байгаа эсвэл үзүүлж байсан хүн

б) нийгмийн үйлчилгээнд хамрагдаж байгаа болон үзүүлсэн хүний хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч, дэмжигч;

с) Нийгмийн үйлчилгээ үзүүлж байгаа болон үзүүлсэн хүн эрүүл мэндийн байдал, нас барсан зэрэг шалтгааны улмаас гомдол гаргах боломжгүй бол ойр дотны хүн,

д) Нийгмийн үйлчилгээ үзүүлж байгаа буюу үзүүлсэн этгээдээс эрх олгосон этгээд,

е) Нийгмийн үйлчилгээ үзүүлж байгаа буюу үзүүлсэн хүний гэр бүлийн гишүүн,

Иргэний хуулиар тухайн хүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн, эсвэл

ф) Нийгмийн үйлчилгээ үзүүлэгчийн ажилтан (цаашид “гомдол гаргагч” гэх).

Санал гомдлыг ямар хэлбэрээр гаргах мөн ямар агуулгатай байх вэ?

- Гомдол гаргагчийн нэр, овог,
- Ямар үйлчигээний талаар гомдол гаргаж буйг тодорхойлох,
- Гомдол гаргагч нь тухайн үйлчилгээний шууд хэрэглэгч мөн эсэх, эсвэл тухайн үйлчилгээний хэрэглэгчтэй ямар холбоотой тухай мэдээлэл (Хэн гомдол гаргах боломжтой хэсгийг үзнэ үү),
- Нийгмийн үйлчилгээ үзүүлж байгаа болон үзүүлсэн этгээдээс итгэмжлэгдсэн этгээдийн итгэмжлэл,
- Гомдлын хариу илгээх гомдол гаргагчийн гэрийн хаяг эсвэл и-мэйл хаяг
- Гомдол хүлээж авсан огноо,
- Гомдлын агуулга – Гомдлын дэлгэрэнгүй тайлбар, тухайлбал, гомдол гаргахад хүргэсэн чухал бодит нөхцөл байдал, түүнчлэн боломжтой бол гомдол гаргагчийн тодорхой мэдүүлэг,
- Гомдол гаргагчийн гарын үсэг

Дээрх шаардлагыг хангаагүй **нэргүй гомдлыг** зөвхөн **санал хэлбэрээр** авч үзэх бөгөөд гомдлыг шийдвэрлэх аргачлалын талаар бичгээр мэдээлэл өгөхөд шаардлагатай гомдол гаргагчийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл байхгүй тул гомдлын горимд шалгаж үнэлэх боломжгүй.

Хугацаа ба гомдлыг бичих хэл

Гомдлын зүйл болсон баримт гарсан өдрөөс хойш 1 жилийн дотор гомдол гаргаж болно.

Гомдлын хариуг таны гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

Гомдлыг чех, орос, украин, монгол, англи хэлээр гаргаж болно. Хэрэв энэ нь өөр хэл дээр байгаа бол үйлчлүүлэгч гомдол гаргахад бичгээр орчуулсан эсвэл орчуулагчтай ирэх ёстой.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хянуулах хүсэлт гаргаж болно. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэнтэй санал нийлэхгүй байгаа болон заасан хугацаанд шийдвэрлэгдээгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчээс гаргасан гомдлын шийдвэрээ бичгээр хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор яаманд хандах боломжтой.

Холбоо барих хаяг:

Ministerstvo práce a sociálních věcí ČR, Na Poříčném právu 1/376, 128 00 Praha 2, telefon: 950 191 111, e.mail: posta@mpsv.cz

Өргөдөл гаргахдаа яагаад гомдлыг хянан шийдвэрлэх талаар хүсэлт гаргаж байгаа тухай мэдээллийг яаманд өгөх ёстой.

Мөн дараах байгууллагуудад хандаж гомдол санал гараж болно:

Байгууллагыг үүсгэн байгуулагч:

Biskupství Královéhradecké (případně administrátor)

Velké náměstí 35, 500 01 Hradec Králové

tel.: 495 063 611

e-mail: biskupstvi@diecezehk.cz

veřejný ochránce práv

Údolní 39

Brno, 602 00

Tel: (+420) 542 542 888, E-mail: podatelna@ochrance.cz

Таны бүх гомдол, санал, санал хүсэлт нь бидний хувьд чухал мэдээлэл бөгөөд манай үйлчилгээний чанарыг сайжруулахад үйлчилдэг.